



ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД
Э.БАТ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.05.29 № 31

Газрын тухай хууль тогтоомжийн
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай хуулиудын биелэлт, Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар олгосон газар өмчлөх, эзэмших эрхийн хэрэгжилттэй холбогдуулан дараах асуулга тавьж байна.

Иргэнд эзэмшүүлэх газрын мэдээлэл, газар олголтын талаар

1.Монгол Улсын иргэдээс 2023-2025 онд ирүүлсэн газар эзэмших хүсэлтийн нийт тоон мэдээллийг аймаг, дүүрэг тус бүрээр, эдгээр хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг хугацаанд нь, хугацаа хоцорсон, шийдвэрлээгүй зэргээр ангилан, шалтгаан, шийдвэрлэсэн дундаж хугацааг нийт хүсэлттэй харьцуулсан байдлаар;

2.Газрын цахим мэдээллийн систем (egazar.gov.mn)-д газар эзэмшихээр хүсэлт гаргасан дарааллын дагуу иргэдэд тухай бүр хариу өгөх явц, мэдээллийн нээлттэй байдал, системийн хэвийн ажиллагааны талаарх санал, гомдол, шийдвэрлэлтийн байдал;

3.Нийслэл болон аймгуудын хэмжээнд дуудлага худалдаа, төсөл шалгаруулалт, дараалалд тулгуурласан газар олголтын хувь хэмжээ, үр дүн;

Нийслэлийн иргэнд өмчлүүлэх газрын төлөвлөгөө

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа газар өмчлөх эрх, Улаанбаатар хотын иргэдийн газар өмчлөх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах талаар Барилга, хот байгуулалтын яамнаас баримталж буй бодлого (Улаанбаатар хотын иргэдээс ирсэн газрын хүсэлтийг шийдвэрлэх тодорхой арга зам, батлагдсан хуваарьт төлөвлөгөө болон хотын иргэдэд зориулж шинээр газар тодорхойлж, нөөц бүрдүүлдэг эсэх, хэрэв нийслэлд өмчлүүлэх газар байхгүй бол Монгол Улсын зөвшөөрөгдсөн бусад нутаг дэвсгэрт буюу аймгуудад хуульд заасны дагуу газар өмчлөх эрхийг иргэдэд олгохын тулд аймгуудтай хамтран ажилладаг эсэх, гарсан үр дүн)-ын талаар;

5.Нийслэлийн хэмжээнд иргэнд өмчлүүлэх, эзэмшүүлэх боломжтой газрыг газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулсан талаарх мэдээлэл, газрын кадастрын нарийчлал, давхар бүртгэлийн зөрчлийн тоо, шийдвэрлэлт;

2020000089

Нөхөн олговор, маргаан, хариуцлага

6.2023-2025 онд хэдэн иргэн, аж ахуйн нэгжийн газрыг чөлөөлсөн, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 39, 40 дүгээр зүйлд заасан журмын дагуу нөхөн олговрыг бүрэн олгосон тохиолдлын хувь, нөхөн олговор хойшилсон болон олгоогүй тохиолдлын тоо, түүний шалтгаан, хойшлогдсон дундаж хугацаа, нөхөн олговрын маргаантай холбоотой шүүхэд бүртгэгдсэн хэргийн тоо, иргэний талд гарсан шийдвэрийн хувь, төсвөөс гарсан нэмэлт зардлын талаарх мэдээлэл;

7.Монгол Улсын иргэдээс 2023-2025 онд ирүүлсэн газар өмчлөх, эзэмших хүсэлтээс татгалзсан шийдвэрийн нийт тоо, татгалзлын гол үндэслэл, газрын маргаантай холбоотойгоор захиргааны хэргийн шүүхэд шилжсэн хэргийн өсөлт, бууралт, шалтгаан, гарсан нөхөн төлбөрийн хэмжээ;

Газрын төлбөр, бүсчлэл, үнэлгээ

8.Газрын төлбөрөөс улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын хувь, газрын орлогыг зориулалтын дагуу ашигласан байдал, газрын төлбөрийн хэмжээ нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдсан эсэх, газрын суурь үнэлгээг тогтоосон Засгийн газрын тогтоолтой холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжийн хэрэгцээг тодорхойлсон судалгаа, бодит нөхцөл байдлын шинжилгээний үр дүн;

9.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (НИТХ)-аас бүсчлэл тогтоохдоо зах зээлийн болон нийгмийн нөхцөл байдал, олон улсын жишиг харгалздаг эсэх, НИТХ-аас бүсчлэлийг олон жил шинэчлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, зохицуулалт, түүний хууль зүйн үндэслэл.

Асуулгын хариуг нотолгоонд тулгуурлаж, тоо баримтад үндэслэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.БААТАРХҮҮ

2026000089